



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 13

Сүхбаатар сум

Комисс томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 66 дугаар зүйлийн 66.1.11, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1, 3.2, 2020 оны Төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 141 дүгээр тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 54 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын албан тушаалын сул орон тооны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Сонгон шалгаруулах комиссын дарга:


Б.Болорзул -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн

Гишүүд:

М.Нямсүрэн -Аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга, Салбар зөвлөлийн гишүүн

Ч.Гандүүрэн -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн

2. Сонгон шалгаруулалтыг зарласан хугацаанд зохих журмын дагуу зохион байгуулан дүнг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг сонгон шалгаруулах комиссын дарга, Салбар зөвлөлийн гишүүн /Б.Болорзул/-д даалгасугай.

ДАРГА  Ө.СУВДАА

УХА0115  
16